ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон. 206, 207, 210, 213 тоот
7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас: 70592439, 70592208, 70593208
И-мэйл: dundgovi@audit.gov.mn

2023. 09. 27. № 1/115.

танай ______ -ны № ______ -т

ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ӨЛЗИЙХИШИГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Луус сумын Мал хамгаалах сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийлээ.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг нөхөн төлүүлэх төлбөрийн актыг хүргүүлж байна. Тогтоосон хугацаанд зөрчлийг арилган хариу ирүүлэхийг хүсье.

Хавсралт 2 хуудас

ДАРГА Р.МӨНХТОГТОХ

0012032639

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2023 оны 09 сарын 27 өдөр Дугаар 91 А/1270318 Мандалговь

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Луус сумын Мал хамгаалах сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд заврын аудит хийлээ.

Өвс, тэжээлийн хяналтын тооллогоор 68,750.00 төгрөгийн 5 шуудай тэжээл дутсан зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 */Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д */эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/* заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т */Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтоно./*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутаасан өвс тэжээлийн 68,750.00 төгрөгийг холбогдох этгээдүүдээр нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Луус сумын Мал хамгаалах сангийн 100081055403 дугаар дансанд шилжүүлэх,

Актын биелэлтийг 2023 оны 10 дугаар сарын 15-ний өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга Б.Өлзийхишиг, нягтлан бодогч Э.Сумъяажаргал, нярав Э.Лхагвасүрэн нарт хариуцуулав.

---

[1] Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

0012050449

Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга Б.Өлзийхишиг, нягтлан бодогч Э.Сумъяажаргал, нярав Э.Лхагвасүрэн нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР Д.ДОЛЖИНСҮРЭН

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

БАТЛАВ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

2023 оны 09 дугаар сарын 27 Луус сум

**МЭДЭГДЭЛ**

Луус сумын Засаг даргын Тамгын газарт

Сонсох ажиллагаа явуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6-р зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Луус сумын Мал хамгаалах сангийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын аудитаар дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Өвс, тэжээлийн хяналтын тооллогоор 68,750.00 төгрөгийн 5 шуудай тэжээл дутсан.

Сонсох ажиллагаа нь дараах дараалаар явагдана. Үүнд:

1. Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг танилцуулах;
2. Захиргааны шийдвэр гаргах асуудлын талаарх үндэслэл, шалтгаан нөхцөлийг танилцуулах;
3. Санал сонсох ;

Мэдэгдлийг гардуулж өгсөн:

Аудитор / Д.Должинсүрэн /

*албан тушаал* *гарын үсэг*

Мэдэгдлийг хүлээн авсан:

Луус сумын Засаг дарга /Б.Өлзийхишиг/

*албан тушаал* *гарын үсэг*

Луус сумын МХС-ийн нягтлан бодогч /Э.Сумъяажаргал/

*албан тушаал* *гарын үсэг*

Мэдэгдлийг гардуулж өгсөн огноо:____________________

# СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 7

Дэлгэрхангай сум

2023 оны 09-р сарын 21-ны өдөр

Захиргааны ерөнхий хуулийн дагуу Луус сумын нягтлан бодогч Э.Сумъяажаргалтай 2023 оны 09 дугаар сарын 27-ны өдрийн 10.30 цагт биечлэн Дундговь аймгийн Төрийн аудитын газрын 210 тоот өрөөнд уулзаж сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагыг төлөөлж:

Албан тушаал, нэр; Луус сумын мал хамгаалах сангийн нягтлан бодогч Э.Сумъяажаргал

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх: үгүй

Татгалзаж байгаа шалтгаан:_________________гарын үсэг_______________

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна. Гарын үсэг____________

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэл, мэдээллийг Луус сумын нягтлан бодогч Э.Сумъяажаргалд танилцуулав.

**Асуулт:** Аудитор Д.Должинсүрэн. Луус сумын Мал хамгаалах сангийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар:

1. Өвс, тэжээлийн хяналтын тооллогоор 68,750.00 төгрөгийн 5 шуудай тэжээл дутсан.

**Асуулт: Аудитор Д.Должинсүрэн**. Завсрын аудитаар хийсэн хяналтын тооллогоор 25 боодол өвс, 5 шуудай тэжээл дутсан, мөн нярвын тайлан, программ 2 зөрүүтэй байсан учраас зөрүүний учрыг олж ирэхээр болсон нотлох баримттай зөрүүний учрыг тайлбарлана.

**Хариулт: Э.Сумъяажаргал**. Санхүүгийн программаа саяхан манай байгууллага шинэчлээд нярав маань шинэ, хуучин 2 программынхаа хооронд будилсан байна. Би ч бас сайн шалгаагүй байна. Дутсан 25 боодол өвс нь 2021 оны жилийн эцсийн тооллогоор хуучин нярав Бямбажаргал дээр дутаад 2022 онд худгийн цалин болон нярвын цалингаас нь суутгасан байна. Харин санхүүгийн программ буюу бүртгэлээс хасаагүй байсан байна.

**Асуулт: Аудитор Д.Должинсүрэн**. Нотлох баримтуудыг харлаа. Тэгэхээр танай сумын хувьд хагас болон жилийн эцсийн тооллогууд нэр төдий тоолоод бүртгэл тайлантайгаа тулгадаггүй байсан байна да. Төлбөрийг нь төлүүлчихээд одоо болтол бүртгэлээс хасаагүй байна гэдэг, 5 шуудай тэжээлийнхээ учрыг олсон уу.

**Хариулт: Э.Сумъяажаргал.** Миний хувьд бас туршлага нилээд муу байлаа үнийг хэлэхэд учраа олохгүй байж байгаад шинэ программтай болоод бүр төөрөөд одоогоос гайгүй юмнуудаа цэгцэлж байна. 5 шуудай тэжээлийн учраа олоогүй манай нярав төлье гэсэн.

**Асуулт: Аудитор Д.Должинсүрэн.:** Одоо өвс тэжээл бага болоод цэгцэрсэн дээр баримт материал, бүртгэл, тайлангаа сайн эмхэлж, цэгцлээрэй. Актын төлбөрийг төлөх хугацааг 2023 оны 10 сарын 15 дотор барагдуулахаар тавилаа болно биз дээ.

**Хариулт: Э.Сумъяажаргал:** Төлбөрийн актын хугацаа 2023 оны 10 сарын 15 дотор төлж барагдуулна.

Сонсох ажиллагааг 2023 оны 09 дугаар сарын 27-ны өдрийн 10.50 цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл: ______________/ Д.Должинсүрэн /

Оролцогч: ______________ /Э.Сумъяажаргал/

**ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**

**Байгууллагын нэр: Луус сумын МХС**

**Тайлант хугацаа: 2023 оны 06 сар**

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Мөнгөн хөрөнгө | Хүлээж аваагүй 2,475,000.00 төгрөгийн 180 шуудай ногоон тэжээлийг санхүүгийн тайланд бүртгэж, орлогодсон. | 2,475,000 | Санхүүгийн тайланг залруулж, авлагаар бүртгэх | Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. Зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байхаар болсон | Санхүүгийн тайланг залруулж, авлагаар бүртгэх | Санхүүгийн тайланг залруулж, авлагаар бүртгэн авлагыг барагдуулах | Засаг дарга, Нягтлан бодогч | Б.Өлзийхишиг, Э.Сумъяажаргал |
| 2 | Бараа материал | Хяналтын тооллогоор 5 шуудай ногоон тэжээл дутсан. | 68,750 | Дутагдсан өвс, тэжээлийг нөхөн төлүүлэх | Хүлээн зөвшөөрсөн 2023 оны 10 сарын 15 өдрийн дотор барагдуулахаар болсон | Төлбөрийн акт тогтоох | Дутагдсан төлбөрийг нөхөн төлүүлэх төлбөрийн актыг нөхөн төлүүлэх | Засаг дарга, Нягтлан бодогч | Б.Өлзийхишиг, Э.Сумъяажаргал |
| 3 | Бараа материал | Тогтоол, шийдвэргүй, устгалын баримт материалгүй 16 шуудай ногоон тэжээлийг акталж, устгасан | 426,250 | Зөрчлийг таслан зогсоож, баримтжуулан, устгалыг хийж байх | Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. Баримт бүрдлийг хангаж ажиллана | Зөвлөмж өгөх | Анхан шатны баримт бүрдлийг хангуулж, ажил гүйлгээг хийж хэвших | Засаг дарга, Нягтлан бодогч | Б.Өлзийхишиг, Э.Сумъяажаргал |
| | | Нийт дүн | 2,970,000 | | | | | | |

Бэлтгэсэн: Аудитор Д.Должинсүрэн Огноо

Хянасан: Аудитын менежер Х.Наранцацрал Огноо

Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох Огноо

Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

Дарга Б.Өлзийхишиг

Нягтлан бодогч Э.Сумъяажаргал

**ААБ 5.2: АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫГ ҮНЭЛЖ, ШИЙДВЭРЛЭХ**

**Байгууллагын нэр: Луус сумын Мал хамгаалах хамгаалах сан**
**Тайлант хугацаа: 2023 оны 06 сар**

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болгосон | | Асуудлыг шийдвэрлэсэн байдал | | | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Холбогдох хууль тогтоомжийн нэр, заалт | Холбогдох стандартын нэр, заалт | Аудиторын санал | Аудитыг хянан удирдах ажилтнуудын санал | | |
| | | | | | | | Менежер | Тэргүүлэх аудитор | |
| A | 1 | 2 | 3 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Мөнгөн хөрөнгө | Хүлээж аваагүй 2,475,000.00 төгрөгийн 180 шуудай ногоон тэжээлийг санхүүгийн тайланд бүртгэж, орлогодсон. | 2,475,000 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; | УСНББОУС-1, 12 Санхүүгийн тайлангийн толилуулга, бараа материал | Залруулах | Залруулах | Залруулах | Залруулсан |
| 2 | Бараа материал | Хяналтын тооллогоор 5 шуудай ногоон тэжээл дутсан. | 68,750 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2 /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ | УСНББОУС-1, 15 Санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулга ба толилуулга | Төлбөрийн акт | Төлбөрийн акт | Төлбөрийн акт | Төлбөрийн акт |
| 3 | Бараа материал | Тогтоол, шийдвэргүй, устгалын баримт материалгүй 16 шуудай ногоон тэжээлийг акталж, устгасан | 426,250 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; | УСНББОУС-1, 15 Санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулга ба толилуулга | Зөвлөмж өгөх | Зөвлөмж өгөх | Зөвлөмж өгөх | Зөвлөмж өгөх |
| | | **Нийт дүн** | **2,970,000** | | | | | | |

Бэлтгэсэн: Аудитор Д.Должинсүрэн

Хянасан: Аудитын менежер Х.Наранцацрал

Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

**ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**

**Байгууллагын нэр: Луус сумын МХС**

**Тайлант хугацаа: 2023 оны 06 сар**

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Мөнгөн хөрөнгө | Хүлээж аваагүй 2,475,000.00 төгрөгийн 180 шуудай ногоон тэжээлийг санхүүгийн тайланд бүртгэж, орлогодсон. | 2,475,000 | Санхүүгийн тайланг залруулж, авлагаар бүртгэх | Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. Зөрчлийг таслан зогсоож давтан гаргахгүй байхаар болсон | Санхүүгийн тайланг залруулж, авлагаар бүртгэх | Санхүүгийн тайланг залруулж, авлагаар бүртгэн авлагыг барагдуулах | Засаг дарга, Нягтлан бодогч | Б.Өлзийхишиг, Э.Сумъяажаргал |
| 2 | Бараа материал | Хяналтын тооллогоор 5 шуудай ногоон тэжээл дутсан. | 68,750 | Дутагдсан өвс, тэжээлийг нөхөн төлүүлэх | Хүлээн зөвшөөрсөн 2023 оны 10 сарын 15 өдрийн дотор барагдуулахаар болсон | Төлбөрийн акт тогтоох | Дутагдсан төлбөрийг нөхөн төлүүлэх төлбөрийн актыг нөхөн төлүүлэх | Засаг дарга, Нягтлан бодогч | Б.Өлзийхишиг, Э.Сумъяажаргал |
| 3 | Бараа материал | Тогтоол, шийдвэргүй, устгалын баримт материалгүй 16 шуудай ногоон тэжээлийг акталж, устгасан | 426,250 | Зөрчлийг таслан зогсоож, баримтжуулан, устгалыг хийж байх | Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. Баримт бүрдлийг хангаж ажиллана | Зөвлөмж өгөх | Анхан шатны баримт бүрдлийг хангуулж, ажил гүйлгээг хийж хэвших | Засаг дарга, Нягтлан бодогч | Б.Өлзийхишиг, Э.Сумъяажаргал |
| | | | | | | | | | |
| | | Нийт дүн | 2,970,000 | | | | | | |

Бэлтгэсэн: Аудитор Д.Должинсүрэн Огноо

Хянасан: Аудитын менежер Х.Наранцацрал Огноо

Тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох Огноо

Зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

Дарга Б.Өлзийхишиг

Нягтлан бодогч Э.Сумъяажаргал